

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/5/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Батцэцэг
Утас: 51-261628 Цахим хаяг: Battsetseqp@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхбулган
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө	13
3.4.2 Авлага	14
3.4.3 Урьдчилгаа	14
3.4.4 Бараа материал	14
3.4.5 Үндсэн хөрөнгө	15
3.4.6 Өр төлбөр	16
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЗБА	Газар зохион байгуулалтын алба
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 793

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан, иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор харьяа газруудад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/214, А/273, А/415 дугаар тушаалуудаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудад 1,062.8 сая төгрөгийн компьютер, принтер, скайнер, геодезийн хэмжилтийн багаж, ширээ, сандал, ханын шүүгээг тус тус хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд харьяа 20 байгууллагын төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 1,879.1 сая төгрөгөөр давж биелсэн ба тус орлогыг нийт дүнгээр шууд захирагчийн санхүүгийн тайланд татаас, санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,015,006.2	34,953,376.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	300,403.8	524,646.9
33	АВЛАГА	3,243,705.4	3,739,840.3
34	УРЬДЧИЛГАА	13,973,702.6	27,716,610.1
35	БАРАА МАТЕРИАЛ	2,497,194.4	2,972,279.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,026,564.6	28,864,490.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,026,564.6	28,864,490.7
39200	Биет хөрөнгө	17,448,350.6	20,596,216.3
39300	Биет бус хөрөнгө	6,578,214.0	8,268,274.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	44,041,570.8	63,817,867.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	243,410.4	3,027,002.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	243,410.4	3,027,002.0
413	Өглөг	10,771.7	2,837,356.6
41400	Урьдчилж орсон орлого	232,638.7	189,645.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	43,798,160.4	60,790,865.1
51	Засгийн газрын хувь оролцоо	43,798,160.4	60,790,865.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	9,014,965.4	8,964,165.3
51200	Хуримтлагдсан үр дүн	33,928,651.4	50,972,671.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	854,543.6	854,028.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,041,570.8	63,817,867.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	466,775,354.1	336,207,092.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,554,438.1	336,207,092.9
120	Нийтлэг татварын бус орлого	15,554,438.1	23,017,655.7
122	Тусламжийн орлого	-	313,189,437.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	451,220,916.0	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	448,759,882.5	319,068,775.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,759,882.5	319,062,172.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,617,192.1	300,560,918.5
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	31,290,106.1	34,534,735.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,987,866.9	4,305,370.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,052,788.1	1,167,229.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,521,041.5	1,773,845.8
2105	Нормативт зардал	22,728.1	22,978.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	497,494.8	444,943.5
2107	Томилолт, зочны зардал	819,139.1	857,774.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,194,720.4	251,395,586.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,231,307.1	6,058,455.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,142,690.4	18,501,254.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,603.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	18,015,471.6	17,138,317.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,435.1	94,812.5
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(43,435.1)	(94,812.5)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	17,972,036.5	17,043,504.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,815,779.9		25,815,779.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,815,779.9		25,815,779.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	10,344.0		10,344.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-		-
6	Тайлант үеийн үр дүн	17,972,036.5		17,972,036.5
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,798,160.4		43,798,160.4
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	515.2		515.2
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,798,675.6		43,798,675.6
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(515.2)		(515.2)
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(50,800.0)		(50,800.0)
12	Тайлант үеийн үр дүн	17,043,504.7		17,043,504.7
13	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,790,865.1		60,790,865.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	460,338,847.7	333,353,310.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,539,314.8	333,353,310.6
120	Нийтлэг татварын бус орлого	7,539,314.8	18,498,667.8
122	Тусламжийн орлого	-	314,854,642.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	452,799,532.9	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,103,926.4	69,265,745.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,103,926.4	69,265,745.3
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,192,339.4	50,603,800.5
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	31,343,304.7	34,531,076.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,019,760.6	4,349,869.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	959,856.4	1,121,312.8
2104	Хангамж, бараа материалын зардал	768,150.3	1,084,382.3
2105	Нормативт зардал	9,875.1	21,142.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	558,756.1	490,634.4
2107	Томилолт, зочны зардал	824,660.4	836,612.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,849,232.9	5,962,102.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,858,742.9	2,206,668.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,911,587.0	18,661,944.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	401,234,921.3	264,087,565.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	401,127,998.0	263,863,322.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	401,127,998.0	263,863,322.2
2200	Дотоод эх үүсвэрээр	401,127,998.0	263,863,322.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(401,127,998.0)	(263,863,322.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	106,923.3	224,243.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	193,480.5	300,403.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,403.8	524,646.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	51,511,768,300.00	49,236,282,438.54	2,275,485,861.46	95.6
Татварын бус орлого	51,511,768,300.00	49,236,282,438.54	2,275,485,861.46	95.6
Нийтлэг татварын бус орлого	2,051,897,300.00	3,915,272,795.02	(1,863,375,495.02)	190.8
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2,051,897,300.00	3,915,272,795.02	(1,863,375,495.02)	190.8
Тусламжийн орлого	49,459,871,000.00	45,321,009,643.52	4,138,861,356.48	91.6
Төсвөөс санхүүжих	49,459,871,000.00	45,321,009,643.52	4,138,861,356.48	91.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,511,768,300.00	47,278,015,723.44	4,233,752,576.56	91.8
УРСГАЛ ЗАРДАЛ	46,078,268,300.00	43,019,695,246.23	3,058,573,053.77	93.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,991,520,400.00	42,182,997,221.32	2,808,523,178.68	93.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,315,942,100.00	31,820,762,387.30	495,179,712.70	98.5
Үндсэн цалин	17,791,080,800.00	17,806,664,712.19	(15,583,912.19)	100.1
Нэмэгдэл	9,128,834,400.00	8,001,549,686.24	1,127,284,713.76	87.7
Унаа хоолны хөнгөлөлт	2,983,546,500.00	3,609,749,488.49	(626,202,988.49)	121.0
Урамшуулал	2,371,194,700.00	2,364,787,800.38	6,406,899.62	99.7
Гэрээт ажлын хөлс	41,285,700.00	38,010,700.00	3,275,000.00	92.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,190,130,800.00	4,058,048,037.99	132,082,762.01	96.8
Тэтгэврийн даатгал	2,787,689,800.00	2,738,332,824.62	49,356,975.38	98.2
Тэтгэмжийн даатгал	361,262,200.00	342,703,693.54	18,558,506.46	94.9
ҮОМШӨ-ний даатгал	181,624,300.00	178,110,145.58	3,514,154.42	98.1
Ажилгүйдлийн даатгал	174,232,700.00	161,933,134.39	12,299,565.61	92.9
Эрүүл мэндийн даатгал	685,321,800.00	636,968,239.86	48,353,560.14	92.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,117,216,800.00	964,197,899.35	153,018,900.65	86.3
Гэрэл, цахилгаан	95,357,800.00	95,099,414.73	258,385.27	99.7
Түлш, халаалт	534,488,500.00	470,449,549.37	64,038,950.63	88.0
Цэвэр, бохир ус	70,430,100.00	54,036,669.25	16,393,430.75	76.7
Байрны түрээс	416,940,400.00	344,612,266.00	72,328,134.00	82.7
Хангамж, бараа материалын зардал	185,352,300.00	157,616,232.23	27,736,067.77	85.0
Бичиг хэрэг	72,956,800.00	55,448,290.50	17,508,509.50	76.0
Тээвэр, шатахуун	44,155,500.00	49,119,152.00	(4,963,652.00)	111.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,052,200.00	33,697,047.73	5,355,152.27	86.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,752,200.00	683,000.00	1,069,200.00	39.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,435,600.00	18,668,742.00	8,766,858.00	68.0
Нормативт зардал	2,524,900.00	322,900.00	2,202,000.00	12.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,524,900.00	322,900.00	2,202,000.00	12.8
Эд хогшил, урсгал засварын зардал	172,973,600.00	168,298,022.53	4,675,577.47	97.3
Багаж, техник, хэрэгсэл	122,991,800.00	123,328,535.03	(336,735.03)	100.3
Урсгал засвар	49,981,800.00	44,969,487.50	5,012,312.50	90.0
Томилолт, зочны зардал	92,741,700.00	75,431,172.00	17,310,528.00	81.3
Гадаад албан томилолт	9,609,200.00	9,609,132.00	68.00	100.0
Дотоод албан томилолт	83,132,500.00	65,822,040.00	17,310,460.00	79.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,536,151,400.00	3,646,952,975.93	1,889,198,424.07	65.9

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,209,922,400.00	3,430,409,226.33	1,779,513,173.67	65.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,296,400.00	1,260,000.00	7,036,400.00	15.2
Даатгалын үйлчилгээ	19,666,000.00	9,162,359.00	10,503,641.00	46.6
Тээврийн хэрэгслийн татвар	3,648,500.00	2,276,987.00	1,371,513.00	62.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,179,300.00	368,300.00	811,000.00	31.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,844,500.00	40,846,603.60	11,997,896.40	77.3
Газрын төлбөр	5,012,900.00	4,017,900.00	995,000.00	80.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	235,581,400.00	158,611,600.00	76,969,800.00	67.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,378,486,800.00	1,291,367,593.99	87,119,206.01	93.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,374,886,800.00	1,288,117,593.99	86,769,206.01	93.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,600,000.00	3,250,000.00	350,000.00	90.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,086,747,900.00	836,698,024.91	250,049,875.09	77.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,411,600.00	-	1,411,600.00	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,411,600.00	-	1,411,600.00	-
Бусад урсгал шилжүүлэг	1,085,336,300.00	836,698,024.91	248,638,275.09	77.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	33,269,200.00	28,494,200.00	4,775,000.00	85.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	715,006,800.00	570,792,051.99	144,214,748.01	79.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	321,464,300.00	237,411,772.92	84,052,527.08	73.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,596,000.00	-	15,596,000.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,433,500,000.00	4,258,320,477.21	1,175,179,522.79	78.4
Тоног төхөөрөмж	1,433,500,000.00	1,433,500,000.00	-	100.0
Бусад хөрөнгө	4,000,000,000.00	2,824,820,477.21	1,175,179,522.79	70.6
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	1,958,266,715.10	(1,958,266,715.10)	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(1,958,266,715.10)	1,958,266,715.10	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(1,958,266,715.10)	1,958,266,715.10	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
Төсвийн байгууллага	23	23	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,036	1,009	27	97.4
Удирдах ажилтан	25	24	1	96.0
Гүйцэтгэх ажилтан	913	889	24	97.4
Үйлчлэх ажилтан	98	95	3	96.9
Гэрээт ажилтан	-	1	(1)	-
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,036	994	42	95.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	879	864	15	98.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	49	51	(2)	104.1
Гэрээт ажилтан	-	1	(1)	-
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	88	78	10	88.6
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	20	17	3	85.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	20	17	3	85.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		21,138,271,350.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		21,138,271,350.27
122	Тусламжийн орлого		21,138,271,350.27
1221	Хандив тусламж /дотоод/		21,138,271,350.27
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		21,138,271,350.27
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10,263,838,809.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,156,952,684.96
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,717,479,856.31
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		20,348,531,651.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,333,785,928.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		9,305,964,496.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,710,313,853.87
210101	Үндсэн цалин		574,496,467.04
210102	Нэмэгдэл		1,202,090,644.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт		70,936,193.93
210104	Урамшуула		158,984,426.33
210105	Гэрээт ажлын хөлс		703,806,122.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		291,821,224.39
210201	Тэтгэврийн даатгал		214,652,242.64
210202	Тэтгэмжийн даатгал		19,171,225.29
210203	ҮОМШӨ-ний даатгал		12,650,970.26
210204	Ажилгүйдлийн даатгал		8,877,753.07
210205	Эрүүл мэндийн даатгал		36,469,033.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		157,114,937.16
210301	Гэрэл, цахилгаан		13,093,973.15
210302	Түлш, халаалт		90,053,963.01
210303	Цэвэр, бохир ус		5,577,001.00
210304	Байрны түрээс		48,390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		926,766,110.40
210401	Бичиг хэрэг		371,080,322.00
210402	Тээвэр, шатахуун		466,718,125.68
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		21,116,526.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		881,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		66,969,436.00
2105	Нормативт зардал		20,820,000.00
210502	Хоол, хүнс		12,820,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,128,168,167.13
210601	Багаж, техник, хэрэгсэл		620,052,639.00
210602	Тавилга		887,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		38,514,000.00
210604	Урсгал засвар		468,713,928.13
2107	Томилолт, зочны зардал		761,180,915.11
210702	Дотоод албан томилолт		761,180,915.11

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,362,959,431.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,346,348,747.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,834,400.00
210803	Даатгалын үйлчилгээ		4,479,745.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		395,929.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,237,000.00
210807	Газрын төлбөр		542,610.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		946,819,856.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		784,264,972.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		162,554,884.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		27,821,432.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		27,821,432.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		25,530,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		491,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		11,014,745,723.00
2200	Дотоод эх үүсвэрээр		11,014,745,723.00
220001	Барилга байгууламж		10,750,596,923.00
222001	Тоног төхөөрөмж		69,148,800.00
223001	Бусад хөрөнгө		195,000,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		789,739,699.20
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(789,739,699.20)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(789,739,699.20)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Цахим ил тод, ухаалаг, тогтвортой газрын харилцааны удирдлагын тогтолцоог хөгжүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сэтгэл ханамжаар үнэлэгдэх үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, кадастр, орон зайн мэдээлэл, технологи, мэдээлэл үйлчилгээ, хот байгуулалт, хот байгуулалтын кадастр, удирдлага, хамтын ажиллагаа, санхүү, эдийн засгийн чиглэлээр дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ гэж тусгажээ. Үүнд:

- Газрын харилцааны чиглэлээр бодлого, чиглэл стратеги, баримт бичгийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Иргэн, олон нийтийн оролцоо, салбар хоорондын уялдааг хангасан, газар, байгалийн нөхцөл, нөөцийн мэдээлэлд суурилсан тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх;
- Газар, үл хөдлөх хөрөнгийг кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэлээр баталгаажуулах, байрлалд суурилсан мэдээллийн санг эрхлэх;
- Газрын биржийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээг өргөжүүлэн, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргаж, салбар дундын суурь судалгаа, мониторингийн мэдээллийн сан байгуулж, газар хамгаалах, нөхөн сэргээх, газрын доройтлыг бууруулах үйл ажиллагааг эрхлэх;
- Орон зайн дэд бүтэц, геодезийн чиглэлээр бодлого чиглэл, стратеги, баримт бичгийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Геодезийн бүх төрлийн сүлжээ, газрын зураг, сэдэвчилсэн тоон зураглалын тогтолцоог хөгжүүлж, газар зүйн нэрийн асуудал болон геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг эрхлэх;
- Орон зайн өгөгдөл, мэдээллийг хадгалах, хамгаалах, түгээх, ашиглах үйл ажиллагаатай холбогдсон бодлого, хууль эрх зүйн орчин, стандартын тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, хяналт- шинжилгээ үнэлгээ, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах;
- Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн төрөлжсөн төрийн архивын үйл ажиллагааг эрхлэх;
- Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн салбарын төрийн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх;
- Санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд шинжилгээ хийх, хянан батлах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Геодези, зураг зүйн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй боловч, төсөвт байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар

тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д өөрчлөлт орсон байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны А/157 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод Сүхбаатар аймгийн ГХБХБГ-ын 0.5 сая төгрөгийн дахин үнэлгээтэй үндсэн хөрөнгийг акталснаар дахин үнэлгээний нөөц 0.5 сая төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн өссөн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,776.3 сая төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	300,403.8	524,646.9	224,243.1
Авлага	3,243,705.4	3,739,840.3	496,134.9
Урьдчилгаа	13,973,702.6	27,716,610.1	13,742,907.5
Бараа материал	2,497,194.4	2,972,279.1	475,084.7
Үндсэн хөрөнгө	24,026,564.6	28,864,490.7	4,837,926.1
Нийт хөрөнгө	44,041,570.8	63,817,867.1	19,776,296.3
Өр төлбөр	243,410.4	3,027,002.0	2,783,591.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	43,798,160.4	60,790,865.1	16,992,704.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	44,041,570.8	63,817,867.1	19,776,296.3

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 524.6 сая төгрөг болж, өмнөх оноос 224.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	49,312.0	524,646.9	475,334.9
Бусад төсөл, нөөцийн харилцах	36,731.4	-	(36,731.4)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	214,360.4	-	(214,360.4)
Дүн	300,403.8	524,646.9	224,243.1

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 224.2 сая төгрөгөөр өссөн нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн ГЗБА-ны гэрээт ажлын барьцаа дансны үлдэгдэл 524.6 сая төгрөг байгаа нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийт 105.9 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан (ГЗБГЗЗЕГ 53.9 сая төгрөг, Архангай аймгийн ГХБХБГ 2.0 сая төгрөг, Булган аймгийн ГХБХБГ 0.7 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ГХБХБГ 34.1 сая төгрөг, Дорноговь аймгийн ГХБХБГ 7.6 сая төгрөг, Дундговь аймгийн ГХБХБГ 2.2 сая төгрөг, Завхан аймгийн ГХБХБГ 5.4 сая төгрөг);
- Нийт 37.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан (Завхан аймгийн ГХБХБГ 19.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ 9.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ГХБХБГ 8.5 сая төгрөг);
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 6.0 сая төгрөгийг зарцуулсан (Баянхонгор аймгийн ГХБХБГ 4.8 сая төгрөг, Дундговь аймгийн ГХБХБГ 1.2 сая төгрөг);
- Нийт 10.6 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг бодитой тооцож үнэлээгүй, илүү тооцож олгосон (Дархан-Уул аймгийн ГХБХБГ 7.6 сая төгрөг, Орхон аймгийн ГХБХБГ 3.0 сая төгрөг);
- Нийт 1.5 сая төгрөгийн цалин хөлсийг илүү, дутуу тооцож олгосон (Баян-Өлгий аймгийн ГХБХБГ ажлаас 0.6 сая төгрөг илүү, Дорнод аймгийн ГХБХБГ 0.9 сая төгрөгөөр дутуу);
- Нийт 4.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон (Баян-Өлгий аймгийн ГХБХБГ 0.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн 1.9 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 1.5 сая төгрөг);
- Нийслэлийн ГЗБА улсын төсвийн санхүүжилттэй давхардуулан орон нутгийн төсвөөс цалин түүнтэй холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 257.9 сая төгрөг төлсөн;
- Нийслэлийн ГЗБА байгууллагын дотоод журамд заагдсан цалинтай чөлөөг 28.1 сая төгрөгөөр эмчилгээ, асаргаа сувилгаанд 344 өдөр, сургалттай холбоотой 129 хоногийн шийдвэр гаргаж хавтгайруулан олгосон;
- Нийслэлийн ГЗБА ээлжийн амралт биеэр эдлээгүй албан хаагчдад батлагдсан хуваарьт амраах боломжгүйг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу 41.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон;
- Баянхонгор аймгийн ГХБХБГ байгууллагын албан хаагчдад олгосон 4.2 сая төгрөгийн цалин нийгмийн даатгалын тайланд мэдээлээгүй;
- Говь-Алтай аймгийн ГХБХБГ өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид тэтгэмжийг тооцохдоо 1 албан хаагчид 0.7 сая төгрөг илүү, 1 албан хаагчид 5.1 сая төгрөг дутуу тооцож олгосон;
- Нийт 13.5 сая төгрөгийн албан томилолтоор ажилласан албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон (Завхан аймгийн ГХБХБГ 1.6 сая төгрөг, Өмнөговь аймгийн ГХБХБГ 11.9 сая төгрөг);
- Говьсүмбэр аймгийн ГХБХБГ Ёс зүйн дэд хорооны гишүүдэд нийт 6.7 сая төгрөгийн урамшууллыг ажлыг үр дүн, гүйцэтгэлийг харгалзан бодитой үнэлээгүй, ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол ирээгүй, ямар нэгэн асуудал шийдвэрлээгүй байхад олгосон;
- Ховд аймгийн ГХБХБГ ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн 0.5 сая төгрөгийн ээлжийн амралтыг тооцоогүй;
- Хэнтий аймгийн ГХБХБГ тайланд онд 16 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 3.6 сая төгрөгийг олгосон;
- Нийслэлийн ГЗБА МУЕС-ын албан даалгаврын хэрэгжилтийг хангаагүй, 2.8 сая төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан;
- Говь-Алтай аймгийн ГХБХБГ тайлант онд автомашины урсгал засварт 22.8 сая төгрөг, ажилчдын нормын хувцас худалдан авахад 8.0 сая төгрөгийг зарцуулсан.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 3,739.8 сая төгрөг болж, өмнөх оноос 496.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	24,727.9	3,226.1	(21,501.8)
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,504,948.9	1,627,369.0	(877,579.9)
Татаас, санхүүжилтийн авлага	680,745.6	2,050,554.7	1,369,809.1
Байгууллагаас авах авлага	4,249.7	19,866.2	15,616.5
Хувь хүмүүсээс авах авлага	29,033.3	38,824.3	9,791.0
Дүн	3,243,705.4	3,739,840.3	496,134.9

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өсөхөд Сангийн сайдын 2026 оны “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 24 дүгээр тушаалаарх татаас, санхүүжилтийн авлага дансны үлдэгдэл 1,879.1 сая төгрөг, Барилгын хөгжлийн төвөөс авах он дамжсан барилга, их засварын захиалагчийн техник хяналтын орлого 1,585.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тус нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Архангай аймгийн ГХБХБГ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн 10.1 сая төгрөгийг байгууллагын төсвөөс олгосон;
- ГЗБГЗЗЕГ тайлант онд харьяа 20 байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелсэн, давсан 1,879.1 сая төгрөгийн орлогыг нийт дүнгээр ГЗБГЗЗЕГ-ын аппаратын санхүүгийн тайланд татаас, санхүүжилтийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг давхардуулан тайлагнасан.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 27,716.6 сая төгрөг болж, өмнөх оноос 13,742.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13,973,702.6	27,716,610.1	13,742,907.5
Дүн	13,973,702.6	27,716,610.1	13,742,907.5

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өсөхөд Нийслэлийн ГЗБА-ны иргэн, ААН байгууллагын газрын нөхөн олговрын урьдчилгаа 27,657.7 сая төгрөг, ГЗБГЗЗЕГ-ын гэрээт ажлуудын он дамжсан гэрээний төлбөрийн үлдэгдэл 58.9 сая төгрөг нь голлон нөлөөлсөн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,972.3 сая төгрөг болж, өмнөх оноос 475.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	159,306.8	117,120.6	(42,186.2)
Эм боох материал	248.1	418.1	170.0
Дуусаагүй үйлдвэрлэл	-	532,925.1	532,925.1
Бэлэн бүтээгдэхүүн	32,452.7	29,397.6	(3,055.1)
Хангамжийн материал	2,288,756.8	2,280,647.7	(8,109.1)

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бичиг хэргийн материал	197,234.8	229,852.9	32,618.1
Аж ахуйн материал	655,381.6	660,283.3	4,901.7
Сэлбэг хэрэгсэл	106,267.7	78,171.5	(28,096.2)
Түлш, шатах тослох материал	17,457.3	19,164.1	1,706.8
Барилгын засварын материал	793.3	3,431.8	2,638.5
Бусад хангамжийн материал	1,311,622.1	1,289,744.1	(21,878.0)
Мал амьтад	16,430.0	11,770.0	(4,660.0)
Дүн	2,497,194.4	2,972,279.1	475,084.7

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,826.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, НҮБ-ын Хүнс, ХАА-н газраас 3.7 сая төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 2,234.3 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, 68.1 сая төгрөгийн бараа материалыг акталж, 1,054.0 сая төгрөгийн хөрөнгийг харьяа газруудад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийт 8.6 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан (Архангай аймгийн ГХБХБГ 1.8 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ГХБХБГ 3.6 сая төгрөг, Орхон аймгийн ГХБХБГ 1.1 сая төгрөг, Өмнөговь аймгийн ГХБХБГ 2.1 сая төгрөг);
- Өмнөговь аймгийн ГХБХБГ 2.4 сая төгрөгийн бичгийн цаас, принтерийн хорны үлдэгдэлтэй тайлагнасан.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 28,864.5 сая төгрөг болж, өмнөх оноос 4,837.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	17,448,350.6	20,596,216.3	3,147,865.7
Барилга, байгууламж, орон сууц	8,623,260.9	8,769,620.2	146,359.3
Авто-тээврийн хэрэгсэл	1,372,330.0	1,658,026.4	285,696.4
Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,280,506.0	8,646,485.0	2,365,979.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,041,422.6	1,388,164.6	346,742.0
Зам, гүүрний барилга байгууламж	10,382.2	4,760.6	(5,621.6)
Бусад үндсэн хөрөнгө	120,448.9	129,159.5	8,710.6
Биет бус хөрөнгө	6,578,214.0	8,268,274.4	1,690,060.4
Программ хангамж	4,113,077.4	5,843,242.9	1,730,165.5
Бусад биет бус хөрөнгө	2,465,136.6	2,425,031.5	(40,105.1)
Дүн	24,026,564.6	28,864,490.7	4,837,926.1

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 5,337.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, НҮБ-ын Хүнс, ХАА-н газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 30.2 сая төгрөг, 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан, иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор харьяа газруудад ГЗБГЗЗЕГ-ын даргын А/214, А/273, А/415 дугаар тушаалаар аймгийн ГХБХБГ-уудад 1,062.8 сая төгрөгийн тавилга, компьютер, тоног төхөөрөмж, Хот байгуулалт, хотын стандартын газраас 61.7 сая төгрөг, НӨХГ-аас хөрөнгө оруулалтаар 459.1 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 113, 119, 230, 474, 669, 673, 691, 717, 740, 760 дугаар тогтоолуудын дагуу 1,104.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж үндсэн хөрөнгөд орлогодсон байна.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,035.4 сая төгрөгийн хөрөнгө акталж, 370.3 сая төгрөгийн хөрөнгө бусад байгууллагад шилжүүлэн, ТӨБЗГ-ын 2025 оны 230 дугаар тогтоолоор Дундговь аймгийн ГХБХБГ-ын эзэмшлийн 58.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий газрыг Шүүхийн тамгын газрын эзэмшилд шилжүүлсэн байна.

Биет бус хөрөнгө: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Биет бус хөрөнгийн дансанд нийт 25 нэр төрлийн 6,549.2 сая төгрөгийн өртөгтэй программ, хангамж бүртгэлтэй бөгөөд тайлант онд программ хангамжийн нэмэлт хөгжүүлэлтэд 1,857.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,027.0 сая төгрөг болж, өмнөх оноос 2,783.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	1,343.4	35.5	(1,307.9)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	859.5	-	(859.5)
Байгууллагад төлөх өглөг	8,465.3	2,706,892.6	2,698,427.3
Хувь хүмүүст өгөх өглөг	103.5	130,428.5	130,325.0
Урьдчилж орсон орлого	232,638.7	189,645.4	(42,993.3)
Дүн	243,410.4	3,027,002.0	2,783,591.6

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 30.2 сая төгрөг, ГЗБГЗЗЕГ-ын гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 2,734.9 сая төгрөг, Нийслэлийн ГЗБА-ны гэрээт ажлын барьцаа 27.9 сая төгрөг, Дорноговь аймгийн ГХБХБГ-ын ТӨБЗГ-т төвлөрүүлэх байсан автомашины дуудлага худалдааны орлого 18.5 сая төгрөг, Увс аймгийн ГХБХБГ-ын түлш, халаалтын өглөг 15.2 сая төгрөг, Говь-Алтай, Төв аймгийн ГХБХБГ-ын түлш халаалт, НДШ, харуулын зардлын өглөг 10.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь өр төлбөрийн дансны өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Дархан-Уул аймгийн ГХБХБГ 3.6 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Төв аймгийн ГХБХБГ байгууллагад төлөх өглөгийн дүнг 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 60,790.9 сая төгрөг болж, өмнөх оноос 16,992.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,014,965.4	8,964,165.4	(50,800.0)
Хуримтлагдсан үр дүн	33,928,651.4	50,972,671.3	17,044,019.9
Өмнөх үеийн үр дүн	15,956,614.9	33,929,166.6	17,972,551.7
Тайлант үеийн үр дүн	17,972,036.5	17,043,504.7	(928,531.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	854,543.6	854,028.4	(515.2)
Дүн	43,798,160.4	60,790,865.1	16,992,704.7

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 7,043.5 сая төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлгээний зөрүү 515.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 170,338.3 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,295.4 сая төгрөгөөр бүрдүүлэхээр, нийт зарлагыг 173,633.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, үйлчилгээний зардлыг 9,116.5 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 397.6 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 104,060.3 сая төгрөг, нийт 113,574.4 сая төгрөгөөр зардлыг бууруулж, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 56,783.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,275.4 сая төгрөг, нийт 60,059.3 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна. Үүнээс: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт 19,683.4 сая төгрөг, орон нутгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудад 40,375.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийн бараа, үйлчилгээний зардлыг 9,893.8 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 87.2 сая төгрөг, нийт 9,981.0 сая төгрөгөөр зардлыг бууруулж, 50,078.3 сая төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр, улсын төсвөөс 46,863.8 сая төгрөгийн санхүүжилт, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,915.3 сая төгрөг, нийт 50,779.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 42,183.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 836.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 4,258.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,501.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 47,278.0 сая төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 943.5 сая төгрөг, газрын зургийн зардлыг 1,175.2 сая төгрөг, газрын хянан баталгааны зардлыг 1,699.2 сая төгрөг, холбооны суваг ашигласны хөлс 0.3 сая төгрөг, байр ашиглалтын үйлчилгээний зардлыг 70.7 сая төгрөг, Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж 1.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 248.6 сая төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 3.7 сая төгрөг, барилгын техник хяналтын зардлыг 91.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
1	71504	Газрын зураглал, кадастор	51,511,768.3	47,278,015.7	4,233,752.6	91.8
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	38,777,935.9	37,834,439.6	943,496.3	97.6
3	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал	62,827.5	62,793.3	34.2	99.9
4	80211	Газрын зургийн зардал	4,001,479.5	2,826,299.9	1,175,179.6	70.6
5	80212	Газрын хянан баталгааны зардал	4,045,671.5	2,346,477.4	1,699,194.1	58.0
6	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	47,608.2	47,608.2	-	100.0
7	80220	Холбооны суваг ашигласны хөлс	499,841.4	499,520.6	320.8	99.9
8	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	421,117.3	350,416.3	70,701.0	83.2
9	80509	Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	1,411.6	-	1,411.6	-
10	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,085,336.3	836,698.0	248,638.3	77.1
11	80918	Бусад	1,433,500.0	1,433,500.0	-	100.0
12	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	118,079.0	114,359.3	3,719.7	96.8
13	82404	Барилгын техник хяналт	1,016,960.1	925,903.1	91,057.0	91.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 85 орон тоотой байхаар баталсан. Батлагдсан тогтоолын хүрээнд тус газар нь сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8.4 дэх хэсэг, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/376 дугаар тушаалаар хоолны хөнгөлөлтийг 35,000 төгрөг, унааны хөнгөлөлтийг 1,000 төгрөг байхаар баталсан байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд тайлант онд гүйцэтгэлээр хоол, унааны хөнгөлөлтөд 3,680.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь тайлант онд газрын даргын А/118, А/165 дугаар тушаалуудаар ОХУ-ын Эрхүү хот, БНХАУ-ын Дэчин хотын гадаад томилолтын зардалд 14.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, Орон зайн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг, Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн системийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн сургалт, Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх талаар мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, Хаягийн мэдээллийн системийн сургалт, Геопортал цахим системийн сургалт, Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт зэргийг албан хаагчдын дунд зохион байгуулж, тайлант онд 42.4 сая төгрөгийг сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардалд зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний бусад зардлаас (210901) 1 гүйцэтгэгчтэй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Монгол улсын баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлын хүрээнд салбарын хууль тогтоомж, мэдээ мэдээллийг ойлгомжтой хүргэх үүднээс ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 19.9 сая төгрөг олгосон байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 21,138.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 20,348.5 сая төгрөгийг зарцуулан, улсын төсөвт 643.1 сая төгрөг, орон нутгийн төсөвт 16.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар 129.9 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 21,138.3 сая төгрөгийн дараах орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 10,263.8 сая төгрөг;
- Дээд шатны төсвийн захирагчаас 7,157.0 сая төгрөг;

- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,717.5 сая төгрөг.

Гүйцэтгэлээр 20,348.5 сая төгрөгийг зарцуулснаас газар чөлөөлөлтийн нөхөн олговорт 10,209.2 сая төгрөг, ГЗБГЗЗЕГ-ын босоо тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, газрын тухай хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох гэрээт ажлуудад 54.7 сая төгрөг, барилга захиалагчийн техник хяналтын зардалд 9,279.1 сая төгрөг, Хэнтий аймгийн ГХБХБГ-ын барилгын лабораторийн барилгын их засвар, өргөтгөл хийхэд 541.4 сая төгрөг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын тоног төхөөрөмж худалдан авахад 264.1 сая төгрөг, зарцуулаагүй үлдэгдэл 789.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, үүнээс 129.9 сая төгрөгийг татаас, санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- ГЗБГЗЗЕГ техник хяналтын зардлын данснаас 50.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар нийт 7,568.3 сая төгрөгийн 31 бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тусгаж анх баталсан ба тайлант онд ГЗБГЗЗЕГ-ын даргын А/19, А/101, А/242, А/282 тушаалуудаар төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Гүйцэтгэлээр 5,349.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 4,566.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 604.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 бараа ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 үйлчилгээг шууд худалдан авах аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ГЗБГЗЗЕГ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй нийт 244.9 сая төгрөгийн шууд худалдан авалт хийж санхүүжилт олгосон;
- ГЗБГЗЗЕГ Газрын зургийн системийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэх 2025/57 тоот гэрээг 2025.04.04-нд ГЗБГЗЗЕГ-ын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн гишүүнтэй байгуулсан;
- Өмнөговь аймгийн ГХБХБГ Алтайн өвөр сав газрын захиргаагаар Хөв цөөрмийн ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх ЗХ-2025/06 тоот гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд 8.2 сая төгрөг олгосон.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ТТЗ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар холбогдох хууль тогтоомж, тушаал зааврын дагуу хөрөнгө бүртгэх, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, толилуулга бэлтгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/647 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 448,998.8 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож 4,490.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 4,748.7 сая төгрөгийн 10 зөрчил илэрсэнд, 1,177.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлж, 3,571.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг харьяа 23 нэгжид хийсэн аудитын дүнгээс нэгтгэхэд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй, байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн нийт 6 харьяа байгууллагын 4,627.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Аудитаар нийт 4,627.3 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, хугацаа хоцроон байршуулсан зөрчилд 1,152.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 3,474.7 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ГХБХБГ шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 425.3 сая төгрөгийн 5 гүйлгээ, байгууллагын даргын 29.0 сая төгрөгийн 10 тушаалыг байршуулаагүй;
- Булган аймгийн ГХБХБГ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 3,350.5 сая төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн;
- Дархан-Уул аймгийн ГХБХБГ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс худалдан авах ажиллагаатай холбоотой 24.0 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроосон, 597.7 сая төгрөгийн 10 гүйлгээг байршуулаагүй;
- Дундговь аймгийн ГХБХБГ Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулбал зохих 76.5 сая төгрөгийн гүйлгээ, хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй;
- Өмнөговь аймгийн ГХБХБГ Шилэн дансны мэдээллийн системд тухайн жилийн батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээний 124.2 сая төгрөгийн 7 ажил гүйлгээг дутуу мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой ГЗБЗЗЕГ болон Өмнөговь аймгийн ГХБХБГ-т илэрсэн нийт 244.9 сая төгрөгийн зөрчилд 205.1 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлж, 39.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 1,051.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулсан.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 524.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	524,347.8	3	524,347.8	100.0
Зөвлөмж	1	-	-	-	-
Нийт дүн	4	524,347.8	3	524,347.8	75.0

Өмнөх оны аудитаар өгсөн харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 289 дүгээр тогтоолоор баталсан удирдамжийн дагуу Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах ажлын хүрээнд хийгдэх төсөл, арга хэмжээний 3,014.3 сая төгрөгийн зардлын гүйцэтгэл болон 1,462.4 сая төгрөгийн өр төлбөрийн гүйлгээг аудитад хамруулж, дүгнэлт хийж чадаагүй болно.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь ТТЗ-ийн нийт батлагдсан төсвийн 32.7 хувийг үйл ажиллагаандаа зарцуулдаг бөгөөд тус газрын ТШЗ-ийн санхүүгийн тайланд тусад нь дүгнэлт гаргаж, аудитад бүрэн хамруулах болон ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 11,943.9 сая төгрөгийн 40 алдаа¹ илэрснээс аудитын явцад 10,064.8 сая төгрөгийн 39 алдааг залруулж, 1,879.1 сая төгрөгийн 1 залруулагдаагүй алдаанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Аудитаар нийт 1,152.4 сая төгрөгийн 59 зөрчил² илэрсэнд, 15.6 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 736.5 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага хүргүүлж, 400.3 сая төгрөгийн зөрчилд 29 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 1,152.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 4,490.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 1,879.1 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс, 1,879.1 сая төгрөгийн 1 алдаа, 1 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Тайлант онд харьяа 20 байгууллагын 1,879.1 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелсэн ба тус давсан орлогыг нийт дүнгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайланд татаас, санхүүжилтийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг давхардуулан тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, 41 дүгээр 41.2.2-т *“Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”*, 20.2.5-д *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль тогтоомжийн дагуу бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан, цалин, урамшуулал давхардуулан олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нийт 1,152.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *“хариуцлагатай байх”*, 6 дугаар зүйлийн 6.1-д *“Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”*, 6.6.1-д *“төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”*, 14 дүгээр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 14.2.3-т “*өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах*”, 15 дугаар зүйлийн 15.4.1-д “*төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх*”, 16 дугаар зүйлийн 16.5.6-д “*дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй зөрчлийг арилгаж, харьяа байгууллагуудын зөрчлийг 20 -оос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Харьяа байгууллага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан байна. Үүнээс 19 байгууллагад “Өөрчлөлтгүй”, Говь-Алтай аймгийн ГХБХБГ, Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгчээ.

Аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 7,992.6 сая төгрөгийн 37 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Харьяа байгууллагуудын аудитаар нийт 1,152.4 сая төгрөгийн 58 зөрчил илэрснээс, 15.6 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 736.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага хүргүүлж, 400.3 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 29 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 4,859.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд санхүүгийн аудитын алдаа, зөрчил 13,096.4 сая төгрөг, нийцлийн аудитын 4,748.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн, “хязгаарлалттай” дүгнэлт авсан харьяа байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд анхаарч ажиллах шаардлагатай байна.

5.3 Түүврийн байгууллага - Газар, зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Аудитаар нийт 380.5 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 295.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 85.5 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөв.

5.3.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: “Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000 масштабтай байр зүйн зураг зохиох ажлын захиалагчийн хяналт хийх” 2024/269, 2024/359 дугаартай ажлын техник хяналтын зардлын 50.0 сая төгрөгийг техник хяналтын зардлын данснаас нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглах бичиг хэргийн материал, шатахуун, засвар үйлчилгээний төлбөр зэргийг төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 29 дүгээр зүйлийн 29.4-т “*Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох зардлын данснаас зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй нийт 245.0 сая төгрөгийн зардалд шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд нийт 53.9 сая төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын дагуух эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд холбогдох эдийн засгийн ангиллаас зарцуулж хэвших.

Илрүүлэлт-2: Газрын зургийн системийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэх 2025/57 тоот гэрээг 2025.04.04нд ГЗБГЗЗЕГ-ын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн гишүүнтэй байгуулж, 2025 онд гүйцэтгэлээр 31.6 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг", 8 дугаар зүйлийн 8.6-д "Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д "Энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан дараах үүргийн аль нэгийг хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах

ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлж, эрх бүхий этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно", 52.5.2-т "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргаагүй, эсхүл худал мэдүүлсэн" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэлгээний хороонд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг худалдан авах ажиллагаанд мөрдүүлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газрын 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Албан шаардлага	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар,зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын нэгтгэл тайлан	3	3,951,352.6			3	3,951,352.6	2	2,072,205.2	1	1,879,147.4	1	1,879,147.4
Дүн	3	3,951,352.6			3	3,951,352.6	2	2,072,205.2	1	1,879,147.4	1	1,879,147.4
Газар,зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар аппарат	7	5,343,925.9	1	1,879,147.4	6	3,464,778.5	7	5,343,925.9				
Дүн	7	5,343,925.9	1	1,879,147.4	6	3,464,778.5	7	5,343,925.9				
Архангай аймгийн ГХБХБГ	2	28,726.0			2	28,726.0	2	28,726.0				
Баянхонгор аймгийн ГХБХБГ	1	68.2			1	68.2	1	68.2				
Говь-Алтай аймгийн ГХБХБГ	4	1,035,702.0	1	772,572.9	3	263,129.1	4	1,035,702.0				
Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	1	10,306.3			1	10,306.3	1	10,306.3				
Дархан-Уул аймгийн ГХБХБГ	1	1,012,168.7	1	1,012,168.7			1	1,012,168.7				
Дорноговь аймгийн ГХБХБГ	5	43,466.2	1	19,018.8	4	24,447.4	5	43,466.2				
Завхан аймгийн ГХБХБГ	3	281,769.9			3	281,769.9	3	281,769.9				
Өмнөговь аймгийн ГХБХБГ	1	4,298.3	1	4,298.3			1	4,298.3				
Төв аймгийн ГХБХБГ	2	13,021.0			2	13,021.0	2	13,021.0				
Увс аймгийн ГХБХБГ	1	25,016.1			1	25,016.1	1	25,016.1				
Хөвсгөл аймгийн ГХБХБГ	5	61,354.3			5	61,354.3	5	61,354.3				
Хэнтий аймгийн ГХБХБГ	2	110,533.0			2	110,533.0	2	110,533.0				
Нийслэлийн ГЗБА	2	22,220.8			2	22,220.8	2	22,220.8				
Дүн	30	2,648,650.8	4	1,808,058.7	26	840,592.1	30	2,648,650.8				
Нийт дүн	40	11,943,929.3	5	3,687,206.1	35	8,256,723.2	39	10,064,781.9	1	1,879,147.4	1	1,879,147.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газар,зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын нэгтгэл тайлан	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Газар, зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар аппарат	4	380,475.3			2	294,949.7	2	85,525.6
Дүн	4	380,475.3			2	294,949.7	2	85,525.6
Архангай аймгийн ГХБХБГ	3	13,882.9	1	1,757.5	2	12,125.4		
Баян-Өлгий аймгийн ГХБХБГ	1	1,405.5	1	1,405.5				
Баянхонгор аймгийн ГХБХБГ	2	9,012.3			2	9,012.3		
Булган аймгийн ГХБХБГ	1	660.0					1	660.0
Говь-Алтай аймгийн ГХБХБГ	7	70,684.8			1	5,814.8	6	64,870.0
Говь-сүмбэр аймгийн ГХБХБГ	2	6,732.0			1	6,732.0	1	-
Дархан-Уул аймгийн ГХБХБГ	5	16,330.6	1	1,484.0	2	6,835.1	2	8,011.5
Дорноговь аймгийн ГХБХБГ	2	7,600.7			1	7,600.7	1	-
Дорнод аймгийн ГХБХБГ	1	979.4	1	979.4				
Дундговь аймгийн ГХБХБГ	2	3,475.3			2	3,475.3		
Завхан аймгийн ГХБХБГ	3	26,463.6	1	1,560.0	2	24,903.6		
Орхон аймгийн ГХБХБГ	2	4,191.7			1	1,150.0	1	3,041.7
Өвөрхангай аймгийн ГХБХБГ	1	1,933.0			1	1,933.0		
Өмнөговь аймгийн ГХБХБГ	6	24,605.0	1	2,072.7	1	11,980.0	4	10,552.3
Сүхбаатар аймгийн ГХБХБГ	3	8,492.3					3	8,492.3
Сэлэнгэ аймгийн ГХБХБГ	1	9,280.8			1	9,280.8		
Төв аймгийн ГХБХБГ	2	3,283.0					2	3,283.0
Ховд аймгийн ГХБХБГ	1	450.5					1	450.5
Хөвсгөл аймгийн ГХБХБГ	4	228,522.1	1	2,750.0	1	82,775.0	2	142,997.1
Хэнтий аймгийн ГХБХБГ	1	3,613.8	1	3,613.8				
Нийслэлийн ГЗБА	4	330,367.4			1	257,895.0	3	72,472.4
Дүн	54	771,966.7	8	15,622.9	19	441,513.0	27	314,830.8
Нийт дүн	59	1,152,442.0	8	15,622.9	22	736,462.7	29	400,356.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн ГХБХБГ	3	479,307.9	2	479,307.9	1	-		
Булган аймгийн ГХБХБГ	1	3,350,526.2			1	3,350,526.2		
Дархан-Уул аймгийн ГХБХБГ	2	621,743.2	1	621,743.2	1	-		
Дундговь аймгийн ГХБХБГ	1	76,543.8	1	76,543.8				
Өмнөговь аймгийн ГХБХБГ	2	220,544.9			2	220,544.9		
Нийслэлийн ГЗБА	1	-			1	-		
Нийт дүн	10	4,748,666.0	4	1,177,594.9	6	3,571,071.1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1080/АДИ75042

Улаанбаатар хот

САГ-2026/5/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд харьяа 20 байгууллагын 1,879,147,406.38 /Нэг тэрбум найман зуун далан есөн сая нэг зуун дөчин долоон мянга дөрвөн зуун зургаан төгрөг гучин найман мөнгө/-ийн үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелсэн ба тус давсан орлогыг нийт дүнгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайланд татаас, санхүүжилтийн авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг давхардуулан тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль тогтоомжийн дагуу бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай), Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч (Г.Халиунбигэр) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
ATA160E7
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-14.Docx

1526191368



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1081/АДИ75042.

Улаанбаатар хот

САГ - 2026/5/НА-СТА-ТТЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан, цалин, урамшуулал давхардуулан олгосон, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нийт 1,152,442,000.00 /Нэг тэрбум нэг зуун тавин хоёр сая дөрвөн зуун дөчин хоёр мянган/ төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй зөрчлийг арилгаж, харьяа байгууллагуудын зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай), Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч (Г.Халиунбигэр) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

9006109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAГ-14.Docx

1526181369



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1082/АД175042

Улаанбаатар хот

САГ-2026/64/НА-СТА-ТШЗ.

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000 масштабтай байр зүйн зураг зохиох ажлын захиалагчийн хяналт хийх" 2024/269, 2024/359 дугаартай ажлын техник хяналтын зардлын 50,000,000.00 /Тавин сая/ төгрөгийг техник хяналтын зардлын данснаас нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглах бичиг хэргийн материал, шатахуун, засвар үйлчилгээний төлбөр зэргийг төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох зардлын данснаас зориулалтын дагуу зарцуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай), Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч (Г.Халиунбигэр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1083/АД175042.

Улаанбаатар хот

САГ - 2026/64/НА-СТА-ТМЗ.

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй нийт 244,949,707.50 /Хоёр зуун дөчин дөрвөн сая есөн зуун дөчин есөн мянга долоон зуун долоон төгрөг тавин мөнгө/-ийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тодотгол хийгээгүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай), Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий санхүүч (Г.Халиунбигэр) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9036109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-14.Docx

1526181372